

**Аймгийн удирдах ажилтнуудын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн
шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг, даалгавар**

2023.11.24

Чойр

№	Үүрэг даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт
1	Төрийн албан хаагчдын нэгдсэн сургалтад албан хаагчдаа бүрэн хамруулах	2023.11.24 08:30 цагт	Бүх байгууллага	Төрийн албан хаагчдын нэгдсэн сургалтад үдээс өмнө 36 байгууллагын 230 албан хаагч, үдээс хойш 26 байгууллагын 98 албан хаагч хамрагдсан байна. Хэрэгжилт 70 хувь
2	Аймаг, сумын төв дээр мал малладаг асуудлыг зогсоож хариуцлага тооцож ажиллах, Багийн Засаг дарга нар уялдаа холбоотой ажиллах	2023.11.27	Сумдын Засаг дарга нар	Сүмбэр сум: Суурьшлын бүсэд мал маллаж, нийтийн эдэлбэр газар болон ногоон байгууламжид малаа бэлчээж, хашаа хайс эвдсэн Сүмбэр сумын 1, 2-р багийн 2 иргэний 16 тооны адуу, 8 тооны үхрийн эздэд Зөрчлийн тухай хуулийн 7.7.2 дахь хэсэгт заасны дагуу холбогдох торгуулийн арга хэмжээг авч, суурьшлын бүсээс малыг гаргасан. Мөн суурьшлын бүсэд малаа бэлчээж байгаа малчин иргэдэд анхааруулга өгч, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн газарт бэлчиж буй малын эзэн холбогдогчийг мэдээлэх тал дээр иргэдтэй хамтран ажиллах тухай бичлэгийг цахимд байршуулсан. Шивээговь сум: Сумын төвд мал малладаг өрхийн судалгааг гаргаж, хариуллагагүй мал явуулахгүй байх талаар малчин 2, мал бүхий 5 өрхтэй уулзаж ЗДТГ, Цагдаагийн хэсгээс малчинтай гурвалсан гэрээ байгуулж, гэрээний дагуу сумын төвд малаа бэлчээсэн тохиолдолд торгуулийн арга хэмжээ болон бусад хариуцлагын арга хэмжээг хүлээлгэхээр заасан. Гэрээний үндсэн дээр үүргээ биелүүлээгүй 2 өрхийг тус бүр 50.0 мянган төгрөгөөр торгосон. Баянтал сум: Сумын төвд хашаандаа мал малладаг өрхүүдийн судалгааг гаргаж, мал сүргийг сумаас гаргах талаар багийн Засаг даргын хугацаатай албан мэдэгдлийг хүргүүлсэн. Хэрэгжилт – 90 хувь
3	Говьсүмбэр аймаг байгуулагдсаны 30 жилийн ойг угтаж байгууллагууд шинэлэг ажил хийж хэрэгжүүлэх, мөн хэрэгжүүлэх ажлын	2023.11.27	Бүх байгууллага	Үүргийн биелэлт ирүүлсэн байгууллагуудаас дараах 23 байгууллага саналаа хүргүүлсэн байна. Үүнд: Татварын хэлтэс, Нийтийн номын сан, Сүмбэр сумын ЗДТГ, Шивээговь сумын ЗДТГ, ОБГ, Илчлэг Шивээ ОНӨҮГ, Эрүүл мэндийн газар, Мал эмнэлгийн газар, Байгаль орчин, аялал

	төлөвлөгөөгөө НБХ-т ирүүлэх			жуулчлалын газар, Статистикийн хэлтэс, Ойн анги, Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Музей, Хүнс, хөдөө, аж ахуйн газар, Боржигин чуулга, Улсын бүртгэлийн хэлтэс, Биеийн тамир спортын газар, Боловсрол, Шинжлэх ухааны газар, Ус Ду ОНӨААТҮГ, Политехник коллеж, Соёл урлагын газар, Нийгмийн даатгалын хэлтэс. Хэрэгжилт 70 хувь
4	Отор нүүдлээр явж буй малчдад мэдээ мэдээллийг цаг алдалгүй дамжуулж, аюулгүй байдлаа хангаж явахад нь мэргэжлийн байгууллагууд анхаарал хандуулж сэрэмжлүүлэг хүргэж ажиллах, багийн Засаг дарга нар үйл ажиллагаагаа эрчимжүүлэх	2023.11.27	Сумдын Засаг дарга нар Холбогдох байгууллагууд	Сүмбэр сумын 3 багийн 33 малчин өрх отор нүүдэл хийхээр төлөвлөөд байгаа бөгөөд 11 дүгээр сарын 20-ны байдлаар 2 багийн 11 малчин өрх /бод-906, бог-10038 нийт 10944 толгой мал/ Дундговь аймгийн Гурвансайхан, Баянжаргалан, Даланжаргалан, Цагаандэлгэр сумд руу отроор яваад байна. Багийн Засаг дарга нар хөдөөгийн малчин өрхүүдтэй өдөр тутам холбогдож цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг хүргэж, отор нүүдэл хийхдээ малын эрүүл мэндийн дэвтэр болон бусад шаардлагатай бичиг баримтаа авч явахыг зөвлөн ажиллаж байна. Шивээговь суманд Дорнод, Хэнтий, Дундговь Төв аймгуудын 6 өрхийн 4547 толгой мал отроор орж ирээд байна. Малчин өрхүүдтэй утсаар холбогдон нөхцөл байдлын талаар мэдээлэл авч, цаашид цаг агаарын уур амьсгалаас шалтгаалах аюулт эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тухайн сум багтайгаа харилцаа холбоотой байж цаг агаарын мэдээ мэдээлэл авч аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөн ажиллаж байна. Баянтал сум: Отор нүүдлээр явж буй малчид болон өөр аймаг сумаас ирж буй малчдын судалгааг гаргаж цаг агаарын болон бусад мэдээллээр хангаж ажиллаж байна. Мал эмнэлэг: Аймаг дундын отрын бүсийн нутгийн захиргаа, сумдын ЗДТГ-тай хамтран 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Малх отрын бүсэд өвөлжих 10 малчин өрхүүдээр орж цаг үеийн нөхцөл байдлын талаар мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлэг хүргэн ажилласан. Хэрэгжилт – 100 хувь
5	Өвс, тэжээл худалдах цэгийг тогтоож, иргэн бүрт хүртээмжтэй үйлчлэх.	2023.11.27	Сумдын Засаг	Сүмбэр сум: Гаднын аймаг сумаас өвс зарж борлуулахаар ирж буй иргэдийг Green House зоогийн газрын хойд талд байрлуулан худалдан борлуулж малчид болон иргэдэд тухай бүр нь мэдээллийг хүргэж байна. Шивээговь сум: Өвс, тэжээл худалдан борлуулах цэгийг

				<p>сумын Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн “Өвс тэжээл худалдан борлуулах түр цэгийг тогтоох тухай” А/161 дугаар захирамжаар тогтоогоод байна. Тус түр цэгт өвс тэжээл худалдан борлуулах борлуулагчтай гэрээ байгуулан ажиллахаар бэлтгэж байна. Одоогоор өвс тэжээл худалдах хүсэлт ирээгүй байна.</p> <p>Баянтал сум: Сумын өвс тэжээлийн агуулах (ангор)-аас Өвс тэжээлийн худалдаа, түгээх цэгийн үйлчилгээг иргэдэд үзүүлэн ажиллаж байна.</p> <p>Хэрэгжилт – 70 хувь</p>
6	Цас их орж зам хаагдаж байгаатай холбогдуулан сумандаа цас зүсэгч /дальпу/ хийж бэлэн байдлаа хангах	2023.11.20	Сумдын Засаг дарга нар	<p>Сүмбэр сум 2 цас зүсэгч буюу дальпуг хийлгүүлсэн. Шивээговь сум “Шивээ Овоо” ХК-нд байдаг 1 ширхэг цас зүсэгчийг ашиглахаар бэлэн байдлыг хангуулсан. Мөн шинээр 2 ширхэг цас зүсэгч /дальпу/ авах хүсэлтийг “Шивээ Овоо” ХК-д хүргүүлсэн.</p> <p>Баянтал сум “Талын Илч” ОНӨҮГ-тай хамтран цас зүсэгч /дальпу/-ийг хийж байна.</p> <p>Хэрэгжилт – 70 хувь</p>
7	Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд төрөөс иргэдэд үзүүлэх хөнгөлттэй үйлчилгээний талаарх мэдээллийг танилцуулах	2023.11.27	Татварын хэлтэс	<p>Улаанбаатар хотод бүртгэлтэй боловч орон нутагт тээвэр, экспортын үйл ажиллагаа явуулж байгаа 44 аж ахуйн нэгжид Татварын хэлтсийн даргын 2023 оны 01/187 тоот албан бичиг хүргүүлж ороннутагт татварын төрлөөр бүртгүүлэхийг мэдэгдсэний дагуу 8 аж ахуйн нэгж шинээр татварын төрлөөр бүртгүүлээд байна.</p> <p>Татварын хэлтэс дэлгэрэнгүй танилцуулга хийнэ.</p> <p>Хэрэгжилт – 100 хувь</p>
Дундаж хэрэгжилт – 81.4 хувь				

ХЯНАСАН: ХШҮХ-ИЙН ДАРГА

М.АНХБАЯР

ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ НЭГТГЭЖ, ҮНЭЛСЭН:
ХШҮХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

О.БОЛОРМАА